

ДОРНОД АЙМАГ ДАШБАЛБАР СУМ

# “ТАНСАГ ТАВИЛГА – ТАНЫ ГЭРТ”

ТӨСӨЛ

Төсөл хэрэгжүүлэгч: “ХАМТЫН ХҮЧ” бүлэг

Утас: .....

Төсөл хэрэгжүүлэх газар: Дашбалбар сумын Улз баг

Төслийн хөрөнгө оруулалт: 29,000,000 төгрөг

2014 он

## **ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.**

Төслийн нэр:	“ТАНСАГ ТАВИЛГА –ТАНАЙ ГЭРТ” модон материалын тавилга үйлдвэрлэл
Төсөл хэрэгжих газар:	Дорнод аймгийн Дашбалбар сумын Улз баг
Төсөл хэрэгжүүлэх салбар:	Хөнгөн үйлдвэр, модон материалын тавилга үйлдвэр
Төслийн хугацаа:	3-н жил
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн:	гэр ахуй, оффисын цэвэр модон тавилга
Төслийн нийт хөрөнгө оруулалт:	29,0 сая төгрөг
Хүсч байгаа санхүүжилтын хэмжээ:	20,0 сая төгрөг
Төсөл хэрэгжүүлэгч:	Дорнод аймаг Дашбалбар сумын “Хамтын хүч” бүлэг
Төсөлд оролцогч:	Дорнод аймаг Дашбалбар сумын Номинт багийн иргэн Боролдой, Д.Ганболд, Баяраа, Цэцгээ нар
Харилцах утас:	

## **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

Модон бүтээгдэхүүнийг захиалагчдын хэрэгцээ, сонголтонд нийцүүлэн дизайн үзэмжийн гоёмсог хийцтэйгээр, чанарын өндөр түвшинд, үйлдвэрлэнэ.

## **ТӨСЛИЙН ЗОРИЛТ:**

- “Хамтын хүч” бүлгийн гишүүд, өөсрдийн боловсруулсан төслийн анхны хөрөнгө оруулалтыг хийж, тавилгын үйлдвэрлэлийн байртай болно.
- Тоног төхөөрөмжөө худалдан авч, тээвэрлэн авчирч, ажлын байрандаа суурилуулан, үйлдвэрлэл эхлүүлэхэд бэлдэнэ.
- Гэр ахуй, сургууль, цэцэрлэг зэрэгт түгээмэл хэрэглэгддэг зарим загвар тавилгуудыг үйлдвэрлэхийн хамт хэрэглэгчдээсээ захиалга авч, хугацаанд нь нийлүүлнэ.
- Төсөл хэрэгжиж дуусах үед “Хамтын хүч” бүлэг нь хоршоо болж өргөжин, үйл ажиллагаа нь тогтворжсон, бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлсэн байх болно.

## **ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ**

Улс орон маань өдрөөс өдөрт хөгжиж байгаатай хамт, хөдөө нутгийн маань иргэд аймаг, хотын иргэдээс дуталгүй, өөрийн гэр орондоо тав тухтай тансаг, өөр өөрийн хүсэл сонирхол, бусадтай адилгүй загвар хийцтэй тавилгатай байхыг хүсдэг болжээ.

Манай сумынхан эрт үеэсээ өөрийн гэсэн байшин саваа сайтар бэлтгэж ирсэн ажилч хөдөлмөрч уламжлал хадгалагдсаар, өвөлжөө, хаваржаа, зусландаа улирал бүртээ зохицсон байшингуудын зэрэгцээ сумын төвд маань сүүлийн үеийн загвар хийц бүхий орон сууцны барилгууд олноороо нэмэгдсээр байна.

Сумын төвд худалдаа эрхэлдэг зарим дэлгүүрүүд, гэр ахуйн тавилгыг цөөн тоогоор хөрш Хятад улсаас тээвэрлэн авчирдаг боловч, холын замд эвдэрч хэмхрэх, үнэ өндөр, загвар хийц нь нэг хэвийн, өнгө, хэмжээ нь өөрчлөх боломжгүй, амархан эвдэрч хэмхэрдэг, нүүдэл, суудлын ая даахгүй гэх зэрэг хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй сул тал ихтэй байна.

“Тансаг тавилга-Таны гэрт” төсөл хэрэгжүүлэгч “Хамтын хүч” бүлгийн гишүүн Д.Боролдой, Баяраа, Д.Ганболд нар нь модоор мужаан хийдэг буриад дархчуулын залгамж хойч үе нь бөгөөд уламжлагдан ирсэн ур ухаан, ажилч хичээнгүй хөдөлмөрч байдлаа, одоо цагийн техник тоног төхөөрөмж ашиглан, хөдөлмөрийн бүтээмж өндөртэй ажиллах туршлага, боломж байна.

Иймд бид захиалагчдын ажлын байр, гэр оронд нь очиж хэмжилт хийж, тэдний өнгө, загвар хийцийн сонголтоор, чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан модон тавилга хийхийн хамт загвар хийц, өнгөний өргөн сонголтыг харуулсан бүтээгдэхүүнээ танилцуулсан тавилгуудыг өөрийн үйлдвэрлэлийн байрнаасаа борлуулна.

## ТӨСЛИЙН ДАВУУ БА СУЛ ТАЛ (SWOT шинжилгээ)

ДАВУУ ТАЛ( <i>domood</i> )	СУЛ ТАЛ( <i>domood</i> )
<ul style="list-style-type: none"> <li>• Өөрийн гэсэн үйлдвэрлэлийн байраа шинээр барьж чадна.</li> <li>• Үйлдвэрлэлийн байршил нь сумын төвдөө</li> <li>• Модон тавилга үйлдвэрлэх сүүлийн үеийн технологи бүхий багаж суурилуулна.</li> <li>• Ажилчдын ур чадвар хангалттай</li> <li>• Бүтээгдэхүүний нэр төрөл олон, захиалагчын хүслээр загвар хийц, хэмжээ, өнгөний сонголт хийх боломжтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн нөөц хязгаардмал</li> <li>• Тоног төхөөрөмжийн эвдрэл</li> <li>• Цахилгааны саатал</li> </ul>

## ТӨСЛИЙН ГАДААД ОРЧИНЫ ШИНЖИЛГЭЭ: (SWOT шинжилгээ)

БОЛОМЖ( <i>гадаад</i> )	АЮУЛ( <i>гадаад</i> )
<ul style="list-style-type: none"> <li>• ЖДҮ дэмжих бодлого сайн</li> <li>• Сум хөгжүүлэх сангийн төслийн зээлийн хүү бага, эргэн төлөлт уян хатан бодлого барьж байгаа.</li> <li>• төвийн эрчим хүчний системд холбогдсон</li> <li>• Сумын зах зээлийн багтаамж боломжийн түвшинд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчний тасалдал хааяа гардаг.</li> <li>• Мөнгөний ханш уналтаас түүхий эдийн үнэ нэмэгдэх магадлалтай.</li> <li>• Өрсөлдөгч нар бий болох</li> </ul>

## ЭРСДЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Эрсдэлийн нэр	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Төсөв, ₮
1	Эрчим хүчний тасалдал	Манай сум нь төвийн эрчим хүчинд холбогдсон, цаашид шугам сайжруулалт хийгдэж байх тул удаан хугацаагаар тасалдал гарах тохиолдол бага.	
2	Тоног төхөөрөмжийн эвдрэл	Тоног төхөөрөмж бүрт угсрах, засварлах, цэвэрлэх, ажиллуулах, эвдрэл гэмтэл гарсан тухай бүрт авах арга хэмжээ зэрэг зааварчилга, журамтай, хувийн хэрэг хөтөлнө. Тухайн тоног төхөөрөмж дээр ажиллах хүн бүр танилцдаг, ашигласан цаг, гарсан гэмтэл, засвар үйлчилгээг хөтөлдөг хэвшил тогтооно. Ингэснээр тухайн тоног төхөөрөмжинд шаардлагатай сэлбэг, хэрэгсэл, цэвэрлэгээ тосолгоог тогтмол хийх боломжтой болно.	50,000
3	Түүхий эдийн үнэ ханш нэмэгдэх	Байнгын гэрээт нийлүүлэгчтэй болно. Түүхий эдийг хаягдалгүй, дахин ашиглах боломжтой.	
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Хөдөлмөр аюулгүй байдлын зааварчилгааг мэргэжлийн зөвлөх байгууллагаас жилд 1 удаа тогтмол сургалт авч байна. Мужааны цех нь өөртөө Хөдөлмөр аюулгүй байдлын зааварчилгаатай болно. Үүнийгээ байнга дагаж мөрддөг соёлыг ажилтан бүрт хэвшүүлнэ. Мужаан бүр Хөдөлмөр хамгааллын хувцас, нүдний шил, бээлий, амны хаалт, малгай хэрэглэж сурна.	50,000 15,000 200,000
БҮГД,₮			315,000

## ТӨСЛИЙН ГАРААНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

ҮНДСЭН ХӨРӨНГӨ		Бүгд,₮	Үүнээс,₮	
			хэрэгжүүлэгч	санхүүжүүлэгч
1	Үйлдвэрлэлийн байр	6,000,000	5,000,000	1,000,000
2	тавилга үйлдвэрлэлийн хагас автомат төхөөрөмж / хөрөө, Тавилгын ирмэгээр туузан наалт наах машин /	8,000,000		8,000,000
3	багаж хэрэгсэл	2,348,000	1,000,000	1,348,000
<b>Бүгд, төгрөг</b>		<b>16,348,000</b>	6,000,000	10,348,000
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>				
1	Түүхий эд худалдан авах	6,000,000		6,000,000
2	Тоног төхөөрөмж суурилуулах	900,000		900,000
3	Цалингийн сан	3,000,000	2,000,000	1,000,000
4	Эрсдэлийн сан	250,000		250,000
5	Элэгдлийн сан	150,000	150,000	
6	Маркетингийн зардал	150,000		150,000
7	Зээл, зээлийн хүү	152,000	150,000	2,000
8	Тээврийн зардал	500,000		500,000
9	Цахилгааны зардал	250,000	100,000	150,000
10	Хөдөлмөр хамгааллын зардал	300,000	100,000	200,000
11	Бусад	1,000,000	500,000	500,000
	<b>Бүгд, төгрөг</b>	<b>12,652,000</b>	3,000,000	9,652,000
<b>ГАРААНЫ ХӨРӨНГӨ Бүгд, төгрөг</b>		<b>29,000,000</b>	9,000,000	20,000,000

Төслийн гарааны нийт хөрөнгө оруулалт 29,0 сая төгрөг.

Үүнээс: Төсөл хэрэгжүүлэгчид 9,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж,

Сум хөгжүүлэх сангаас 20,0 сая төгрөгийн зээлийг 36 сарын хугацаатай авах бөгөөд 2014 онд буюу эхний 7 сарын үндсэн зээлээс чөлөөлөгдөж, 29 сарын хугацаанд зээлийг бүрэн төлж барагдуулна.

## ТӨСЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ БА БОРЛУУЛАЛТ:

Бид бүтээгдэхүүнээ захиалагчийн хүссэн загвар, өнгө, гоёмсог хийцээр хийх тул бүтээгдэхүүний нэр төрөл, овор хэмжээ, тоо ширхэгийн хувьд уян хатан байх болно. Иймд манай төслийн үндсэн бүтээгдэхүүний нэр төрлийг танилцуулвал:

- бүх төрлийн хийц загвар, дизайнтай хаалга
- албан тасалгааны хаалга, хаалт
- гал тогооны тавилга
- хүүхдийн өрөөний тавилга
- албан тасалгааны тавилга
- ханын шүүгээ
- бүх төрлийн модон хийц бүхий ширээ, сандал

№	Бүтээгдэхүүний үнэ	хэмжих нэгж	Нэгж үнэ,₮		1 сард үйлдвэрлэх /борлуулах/ тавилгын тоо		Сарын орлого,₮
			Модон тавилга	ДСП тавилга	Модон тавилга	ДСП тавилга	
1	Гал тогооны тавилга	урт.м	50,000	45,000	3	3	285,000
2	Хувцасны шүүгээ	м.кв	480,000	250,000	1	1	730,000
3	Ор	ш	250,000		1		250,000
4	Хувцас болон номын тавиур	м.кв	80,000	70,000	4	4	600,000
5	Сандал	ш	8,000		8		64,000
6	Ширээ	г	15,000	8,000	2	1	38,000
7	Сандал ширээ	ком	250,000		2		500,000
8	Хаалга	м.кв	60,000	45,000	1	1	105,000
9	Хүүхдийн хичээлийн ширээ	ш	80,000	70,000	1	1	150,000
	<b>Нийт</b>				23	11	<b>2,722,000</b>

## Үйл ажиллагааны төвлөгөө

Хийгдэх ажлууд	Төсөл хэрэгжих жил		
	2014	2015	2016
Үйлдвэрийн байр барих	+		
Тоног төхөөрөмж худалдан авах	+		Сайжруулалт хийнэ.
Тоног төхөөрөмжөө суурилуулна	+		
Түүхий эдийн худалдан авалт	+	+	+
Үйлдвэрлэл явуулах	+	+	+
Борлуулалт	+	+	+
Үзэсгэлэн худалдаанд оролцоно.	Жилд 2 удаа	Жилд 2 удаа	Жилд 2 удаа
ЗДТГ-т төслийн тайлангаа өгч байна.	12 сард	12 сард	12 сард

## Маркетингийн төлөвлөгөө

Маркетингийн иж бүрдэл	Манай бизнесийн хувьд:
Бүтээгдэхүүн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>• Бүтээгдэхүүний нэр, төрөл, загвар хийц, өнгө сонголтын каталогитай байна.</li> <li>• Бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, сайжруулахад тогтмол анхаарч ажиллана.</li> </ul>
Борлуулах үнэ	<ul style="list-style-type: none"> <li>• Бүтээгдэхүүний үнийг тооцохдоо, захиалагчийн хүссэн загвар хийц, өнгөний сонголтын дагуу, зураг-төсөвийг дэлгэрэнгүй хийж, түүхий эд, хөдөлмөрийн хөлс, бусад зардлыг нэг бүрчлэн танилцуулсаны дараа, үнийг харилцан хүлээн зөвшөөрдөг байх бодлогыг баримтална.</li> <li>• Үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөц, олдоцоос хамаарч, борлуулалтыг дараа төлбөрт болон мөнгөн бус хэлбэрээр худалдах, худалдан авах гэрээгээр хийдэг хэлбэрийг ашиглана.</li> </ul>

### Цалин хөлс, урамшууллын зардал:

№	Эрхэлж буй ажил	орон тоо	Үндсэн цалин	Нийт цалин	Төслийн НД-ын зардал	Сард	1 жилд
1	Ахлах мужаан	1	450,000	450,000	49,500	499,500	5,994,000
2	Туслах мужаан	1	350,000	350,000	38,500	388,500	4,662,000
3	Туслах ажилтан	1	300,000	300,000	33,000	333,000	3,996,000
4	Борлуулагч	1	250,000	250,000	27,500	277,500	3,330,000
	<b>Нийт дүн</b>	<b>4</b>		<b>1,350,000</b>	<b>148,500</b>	<b>1,498,500</b>	<b>17,982,000</b>

## ЗЭЭЛ, ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ГРАФИК

Үндсэн зээл: 20,0 сая ₮

Зээлийн жилийн хүү – 3 %

Зээлийн эргэн төлөх хугацаа 36 сар Үндсэн зээлээс чөлөөлөгдөх хугацаа 7 сар

№	Төлбөр хийх огноо	Хоног	Төлбөр			Үлдэгдэл
			Хүү	Үндсэн зээл	Бүгд	
	5/1/2014		3%			20,000,000
1	6/1/2014	31	50,958.90		50,958.90	20,000,000
2	7/1/2014	30	49,315.07		49,315.07	20,000,000
3	8/1/2014	31	50,958.90		50,958.90	20,000,000
4	9/1/2014	31	50,958.90		50,958.90	20,000,000
5	10/1/2014	30	49,315.07		49,315.07	20,000,000
6	11/1/2014	31	50,958.90		50,958.90	20,000,000
7	12/1/2014	30	49,315.07		49,315.07	20,000,000
<b>2014 онд</b>		<b>214</b>	<b>351,780.82</b>		<b>351,780.82</b>	
8	1/1/2015	31	50,958.90	689,655.00	740,613.90	19,310,345
9	2/1/2015	31	49,201.70	689,655.00	738,856.70	18,620,690
10	3/1/2015	28	42,853.09	689,655.00	732,508.09	17,931,035
11	4/1/2015	31	45,687.29	689,655.00	735,342.29	17,241,380
12	5/1/2015	30	42,512.99	689,655.00	732,167.99	16,551,725
13	6/1/2015	31	42,172.89	689,655.00	731,827.89	15,862,070
14	7/1/2015	30	39,111.95	689,655.00	728,766.95	15,172,415
15	8/1/2015	31	38,658.48	689,655.00	728,313.48	14,482,760
16	9/1/2015	31	36,901.28	689,655.00	726,556.28	13,793,105
17	10/1/2015	30	34,010.40	689,655.00	723,665.40	13,103,450
18	11/1/2015	31	33,386.87	689,655.00	723,041.87	12,413,795
19	12/1/2015	30	30,609.36	689,655.00	720,264.36	11,724,140
<b>2015 онд</b>		<b>365</b>	<b>486,065.22</b>	<b>8,275,860.00</b>		
20	1/1/2016	31	29,872.47	689,655.00	719,527.47	11,034,485
21	2/1/2016	31	28,115.26	689,655.00	717,770.26	10,344,830
22	3/1/2016	29	24,657.54	689,655.00	714,312.54	9,655,175
23	4/1/2016	31	24,600.86	689,655.00	714,253.86	8,965,520
24	5/1/2016	30	22,106.76	689,655.00	711,761.76	8,275,865
25	6/1/2016	31	21,086.45	689,655.00	710,741.45	7,586,210
26	7/1/2016	30	18,705.72	689,655.00	708,360.72	6,896,555
27	8/1/2016	31	17,572.04	689,655.00	707,227.04	6,206,900
28	9/1/2016	31	15,814.84	689,655.00	705,469.84	5,517,245
29	10/1/2016	30	13,604.17	689,655.00	703,259.17	4,827,590
30	11/1/2016	31	12,300.43	689,655.00	701,955.43	4,137,935
31	12/1/2016	30	10,203.13	689,655.00	699,858.13	3,448,280
<b>2016 онд</b>		<b>366</b>	<b>238,639.68</b>	<b>8,275,860.00</b>		
32	1/1/2017	31	8,786.03	689,655.00	698,441.03	2,758,625
33	2/1/2017	31	7,028.83	689,655.00	696,683.83	2,068,970
34	3/1/2017	28	4,761.47	689,655.00	694,416.47	1,379,315
35	4/1/2017	31	3,514.42	689,655.00	693,169.42	689,660
36	5/1/2017	30	1,700.53	689,660.00	691,360.53	-
<b>2017 онд</b>		<b>151</b>	<b>25,791.27</b>	<b>3,448,280.00</b>		
			<b>1,102,276.98</b>	<b>20,000,000.00</b>		



ТӨСЛИЙН ОРЛОГО ба ЗАРДЛЫН ТӨСӨВЛӨЛТ: ( сараар )

Үзүүлэлт			Төсөлхэрэгжих жний жил 2014 оны 6 сараас 2015 оны 5 сар дуустал											
			6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	01-р сар	02-р сар	03-р сар	04-р сар	05-р сар
<b>ОРЛОГО</b>	1	Эхлэлтийн мөнгөн хөрөнгө	20,000,000											
	2	Бордуулалтын орлого	1,500,000	2,500,000	3,200,000	3,200,000	3,200,000	3,200,000	3,200,000	3,200,000	3,200,000	3,200,000	3,200,000	3,200,000
	3	Бусад орлого/зээл	9,000,000											
	<b>НИЙТ ОРЛОГО</b>		<b>30,500,000</b>	<b>2,500,000</b>	<b>3,200,000</b>	<b>3,200,000</b>	<b>3,200,000</b>	<b>3,200,000</b>	<b>3,200,000</b>	<b>3,200,000</b>	<b>3,200,000</b>	<b>3,200,000</b>	<b>3,200,000</b>	<b>3,200,000</b>
<b>ЗАРЛАГА</b>	1	Тоног төхөөрөмж	10,348,000											
	2	Түүхий эд	6,000,000			2,000,000			2,000,000			2,000,000		2,000,000
	3	Бордуулалтын зардал	100,000	100,000	100,000		100,000		100,000			100,000		
	4	Үйлдвэрлэлийн зардал/байр барих	8,750,000	250,000	250,000	250,000	250,000	250,000	250,000	250,000	250,000	250,000	250,000	250,000
	5	Цалингийн сан	1,350,000	1,350,000	1,350,000	1,350,000	1,350,000	1,350,000	1,350,000	1,350,000	1,350,000	1,350,000	1,350,000	1,350,000
	6	Эрсдэлийн сан	100,000		50,000		50,000		50,000		50,000		50,000	
	7	Бусад зардал	2,500,000			100,000		100,000		100,000		100,000		100,000
	8	Зээл, зээлийн хүү	50,959	49,315	50,959	50,959	49,315	50,959	49,315	740,614	738,857	732,508	735,342	732,168
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>29,198,959</b>	<b>1,749,315</b>	<b>1,800,959</b>	<b>3,750,959</b>	<b>1,799,315</b>	<b>3,750,959</b>	<b>1,799,315</b>	<b>4,440,614</b>	<b>2,388,857</b>	<b>4,532,508</b>	<b>2,385,342</b>	<b>4,432,168</b>
<b>ТАТВАР НООГДУУЛАХ ӨМНӨХ ОРЛОГ</b>			1,301,041	750,685	1,399,041	(550,959)	1,400,685	(550,959)	1,400,685	(1,240,614)	811,143	(1,332,508)	814,658	(1,232,168)
<b>ААНОАТ-ЫГ 10%</b>			130,104	75,068	139,904		140,068		140,068		81,114		81,466	
<b>ЦЭВЭР АШИГ</b>			1,170,937	675,616	1,259,137	(550,959)	1,260,616	(550,959)	1,260,616	(1,240,614)	730,029	(1,332,508)	733,192	(1,232,168)
<b>ХУРИМТЛАГДСАН ЦЭВЭР АШИГ</b>				1,846,553	3,105,690	2,554,732	3,815,348	3,264,389	4,525,005	3,284,392	4,014,421	2,681,912	3,415,104	2,182,936



## ТӨСЛИЙН ҮР АШГИЙН ТӨЛӨВЛӨЛТ (жилээр)

Үзүүлэлт		2015 он	2016 он	2017 он	БҮГДҮ	
ОРЛОГО	1	Эхлэлтийн мөнгөн хөрөнгө	20,000,000			20,000,000
	2	Борлуулалтын орлого	36,000,000	45,000,000	54,000,000	135,000,000
	3	Бусад орлого/зээл	9,000,000			9,000,000
	<b>НИЙТ ОРЛОГО</b>		<b>65,000,000</b>	<b>45,000,000</b>	<b>54,000,000</b>	<b>164,000,000</b>
ЗАРЛАГА	1	Тоног төхөөрөмж	10,348,000		5,000,000	15,348,000
	2	Түүхий эл	16,000,000	15,000,000	15,000,000	46,000,000
	3	Борлуулалтын зардал	600,000	300,000	300,000	1,200,000
	4	Үйлдвэрлэлийн зардал	11,500,000	1,500,000	1,500,000	14,500,000
	5	Цалингийн сан	16,200,000	17,982,000	17,982,000	52,164,000
	6	Эрсдэлийн сан	350,000	350,000	350,000	1,050,000
	7	Бусад зардал	3,000,000	1,200,000	1,200,000	5,400,000
	8	Зээл, зээлийн хүү	4,031,270	8,660,064	8,410,943	21,102,277
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>62,029,270</b>	<b>44,992,064</b>	<b>49,742,943</b>	<b>156,764,277</b>
<b>ТАТВАР НООГДУУЛАХ ӨМНӨХ ОРЛОГО</b>		<b>2,970,730</b>	<b>7,936</b>	<b>4,257,057</b>		
<b>ААНОАТ-ЫГ 10%</b>		<b>297,073</b>	<b>794</b>	<b>425,706</b>		
<b>ЦЭВЭР АШИГ</b>		<b>2,673,657</b>	<b>7,142</b>	<b>3,831,351</b>		
<b>ТЛАГДСАН ЦЭВЭР АШИГ</b>			<b>2,680,800</b>	<b>6,512,151</b>	<b>6,512,151</b>	

## ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төслийн үр дүнд сумын ЖДҮ-ийн тоог нэгээр өсгөснөөр, ЖДҮ-ийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоонд, тогтмол ажлын байрыг дөрвөөр нэмэгдүүлсэнээр, сумын ажилгүй иргэдийн тоог бууруулахад зохих хувь нэмрээ оруулна.

Сумын орон нутгийн ХАОАтатварт 5,394,600 төгрөг, НДШ-д 5,346,000 төгрөг, Сум хөгжүүлэх сангаас авсан 20,0 сая төгрөгийн зээлийн хүү болох 1,1 сая төгрөгөөр арвижуулна.

Төслийн мөнгөн хуримтлалын цэвэр ашиг нь 6,512,151 төгрөг болсон байхаас гадна, өөрийн гэсэн үйлдвэрлэлийн байртай, тоног төхөөрөмжтэй, орон нутгийн зах зээлд танигдсан, байнгын захиалагчтай, үзэсгэлэн худалдаанд тогтмол оролцож, бүтээгдэхүүнээ танилцуулдаг байна.

Төслийн эцэст, өөрийн гэсэн үйлдвэрлэлийн байртай, захиалагчдын найдвартай харилцагч, тогтмол тавилга үйлдвэрлэгч, цаашдын хөгжлийн урт хугацааны бизнес төлөвлөгөөтэй болсон байх болно.

#### **ТӨСЛИЙН ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД:**

1. Төсөл хэрэгжүүлэгчдээс, санхүүжүүлэгч талд хандсан өргөдөл
2. Шинээр худалдан авах тоног төхөөрөмжийн судалгаа, танилцуулга, зураг
3. Шинээр барих/засварлах ажлын байрны зураглал, тооцоо
4. Төслийн бүтээгдэхүүний зурагт танилцуулга